

СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЛОГИК ЗӨРЧИЛ  
БА БЭРХШЭЭЛҮҮД

М. Зулькафиль\*

\* МУИС-ийн ШУС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc. D)

**Түлхүүр үг:** мэдээллийн шинэ технологи, арилжааны сэтгүүл зүй, аналитик сонин хэвлэл, даяар сүлжээний харилцаа, интерактив шинж, мэргэжлийн парадокс

**С**этгүүлчийн мэргэжил бол нийтийн, нийгмийн шинжтэй мэргэжил. Ирлээ, харлаа, бичлээ, хальсанд буулгалаа, зураг авлаа, сонинд эсвэл эфирт өглөө. Сэтгүүлч үргэлж олны нүдэнд ил, үйл явдлын дунд байна. Гэхдээ хэрэв энэ мэргэжлийн онцлог юу вэ, бусад мэргэжлээс юугаар ялгаатай вэ гэж асуувал ихэнх нь амархан хариулж чадахгүй гэдэг нь тодорхой. Сэтгүүлчийн мэргэжлийн учир утгыг тайлахаас өмнө мэргэжил хэмээх ойлголтын талаар товч ярья.

Мэргэжил гэсэн ойлголт латины *professio* гэсэн үгнээс эхтэй бөгөөд *profiteor* буюу “өөрийнхөө ажлыг зарлах, мэдүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, лекц унших, хичээл заах, санал болгох, үзүүлэх” гэсэн утгатай үйл үгнээс гаралтай ажээ. Профессор гэдэг үг ч энэ үгнээс гарчээ. Мэргэжил гэдэг бол тусгай бэлтгэл, ажлын туршлагын үр дүнд олж авсан онолын цогц мэдлэг, практик дадлыг эзэмшсэн хүмүүсийн

хөдөлмөрийн үйл ажиллагааны тодорхой төрлийг илэрхийлдэг<sup>1</sup>. Товчоор хэлбэл мэргэжил нь урлаг спорт, шинжлэх ухаан, техникийн тодорхой салбарын мэдлэгийг системтэй эзэмшсэн мэдлэг чадвар юм.

Мэргэжил нь дотроо мэргэшилд (латины *specials* – өвөрмөц онцлог, эр өөр шинжтэй) буюу тухайн мэргэжлийн хүрээнд үйл ажиллагааны тодорхой төрөл, чиглэлд хуваагддаг. Бид энд мэргэжлийн тухай ярих юм бол сэтгүүл зүйн мэргэжил буюу журнализмын тухай, мэргэшлийн туай ярих юм бол сонины, радио, телевизийн, цахим хэвлэлийн, мэдээллийн агентлагийн сэтгүүлчийн тухай ярина гэсэн үг юм. Мөн сүүлийн жилүүдэд сэтгүүлч бэлтгдэг их дээд сургуулиудад реклам сурталчилгааны болон пиарын (PR) мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсэн. Мэргэшлийн хүрээнд ажилтнуудыг үйл ажиллагааны төрөл болон бичлэгийн төрөл зүйлээр дагнан мэргэшүүлж болно. Тухайлбал, сурвалжлагч, тайлбарлагч, тоймч, хөтлөгч, эрэн сурвалжлагч, хянан найруулагч г. м. Үүнээс гадна сэтгүүлчид улс төрийн, эдийн засгийн, спортын, соёл урлагийн, экологийн, олон улсын, эрх зүйн гэх мэт тодорхой нэг сэдвийн дагуу дагнан

мэргэших хандлага түгээмэл байдаг. Үүнийг профилизааци буюу нарийн мэргэших гэж нэрлэдэг. Сэтгүүлчдийн дээрх мэргэшлийн төрөл, хэлбэр, чиглэл болгон өөрийн гэсэн өвөрмөц онцлог шинжүүдтэй бөгөөд энэ нь тогтвортой мэдлэгийн, дадлын болон хөдөлмөрийн үйлдлээр тодорхойлогдоно.

Оросын мэргэжил судлаач эрдэмтэн Е. А. Климов мэргэжлийг дараах таван том хэв маягт хуваасан байдаг.

*Социономи (латины societas – нийгэм) шинжтэй буюу нийгмийн шинжийг* агуулсан мэргэжлүүд. Энэ ангилалд багтдаг мэргэжлүүд үйл ажиллагааны явцад “хүн-хүн” гэсэн харилцааг илэрхийлдэг онцлогтой. Тухайлбал, багш, худалдагч, тайлбарлагч г. м.

*Сигнономи (латины signum – тэмдэгт) шинжтэй* мэргэжлүүд. Энэ бол үйл ажиллагааны явцад байнга тэмдэгтүүдийн системтэй харилцадаг, “хүн-тэмдэгт” гэсэн харилцааг илэрхийлдэг мэргэжлүүд юм. Тухайлбал, няптан бодогч, программ зохиогч г. м.

*Артономи шинжтэй* буюу үйл ажиллагааны явцад уран сайхны дүрийн системтэй харьцдаг, “хүн-уран сайхны дүр” гэсэн харилцааг илэрхийлдэг мэргэжлүүд. Тухайлбал, зохиолч, зураач г. м.

**Х**өдөө аж ахуйн шинжтэй мэргэжлүүд буюу үйл ажиллагааны явцад байгаль, хүрээлж буй орчинтой харьцдаг, “хүн-байгаль” гэсэн харилцааг илэрхийлдэг мэргэжлүүд. Тухайлбал, агрономич, ой хамгалагч, тариаланч г. м.

*Техникийн шинжтэй* буюу үйл ажиллагааны явцад техникийн системтэй харьцдаг, “хүн-машин” гэсэн харилцааг илэрхийлдэг мэргэжлүүд. Тухайлбал, жолооч, токарьчин, механикч г. м.<sup>2</sup>

Сэтгүүлчийн мэргэжил дээрх таван ангиллын дор хаяж эхний гуравт нь

багтах нь тодорхой юм. Мөн орчин үед мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж, мэдээллийн үйл ажиллагааг цахимжүүлэх үйл явц идэвхтэй нэвтэрч байгааг харгалзан үзвэл өнөөдөр сэтгүүлчийн мэргэжил техникийн шинжийг ч тодорхой хэмжээгээр агуулж эхэлснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэрэв мэдээллийг өргөн утгаар нь ойлгож, түүний хамрах хүрээ, агуулга, нийгэм-байгалийн системийг харгалзан үзвэл сэтгүүлчийн мэргэжил “хүн-байгаль” гэсэн харилцааг илэрхийлдэг мэргэжилд ч шууд бус хамаарах болно. Энэ бүхнээс үзэхэд сэтгүүлчийн мэргэжлийн хүрээ маш өргөн гэдэг нь тодорхой юм. Гэхдээ сэтгүүлчийн мэргэжлийг мэдээлэл, үг яриа, хүмүүжил, харилцаа, уран бүтээл, нийгмийн үйл ажиллагаатай холбоотой ойр мэргэжлүүд буюу социономи, артономи, сигнономи шинжтэй мэргэжлүүдтэй харьцуулж үзвэл улам ойлгомжтой, арай гүнзгий мэдлэг олж авахад туслах болно. Энэ бол мэдээллийн, олон нийтийн харилцааны, судалгааны, хүмүүжлийн, уран бүтээлийн шинжтэй мэргэжлүүд юм. Үүнд өргөн утгаар нь багш, зохиолч, улстөрч, төрийн, нийгмийн зүтгэлтэн, уран илтгэгч, урлагийн ажилтан, судлаач, түүхч, шүүгч, шашны номлогч нарыг оруулж үздэг.

Мэргэжлийг ангилах нь түүний гүйцэтгэх үүрэгтэй шууд холбоотой. Шинжлэх ухаан танин мэдэхүйн хэрэгсэл, үзэл суртлын хэлбэрүүд бол үнэлэмжийн баримжааг олох хэрэгсэл, улс төр бол нийгэм, улс төрийн зохицуулалтын хэрэгсэл, урлаг бол гоо зүйн хөгжлийн хэрэгсэл гэх мэтээр ярьж болно. Сэтгүүл зүй олон нийтийг мэдээллээр хангах хэргслийн хувьд дээрх бүх үүргийг гүйцэтгэдэг онцлогтой. Сэтгүүл зүй ямар нэг байдлаар



дээрх үүргүүдийг гүйцэтгэдэг боловч өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой мэргэжил юм.

1990 оноос хойш ардчилсан нийгэмд шилжих үйл явц сэтгүүл зүйн мэргэжил, түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг зорилго, ач холбогдол, үнэ цэн, эзлэх байр суурийн талаарх төсөөллийг ихээхэн өөрчилж, энэ асуудалд арай өөр өнцгөөс харах шаардлага тулгарсан. Нэг намын үзэл суртал, ухуулан хүмүүжүүлэх зэвсэг байсан сэтгүүл зүй мэдээллийн зах зээлийн хуулиас шууд шалтгаалдаг арилжааны сэтгүүл зүй болон хувирсан юм. Ахар богино хугацаанд ХМХ-ийн тоо эрс нэмэгдэж, хүлээн авагчдын янз бүрийн хэрэгцээ, сонирхлыг харгалзсан янз бүрийн хэв маяг, чиглэл, төрөл хэлбэрийн сонин хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэг бий болсон. Хэвлэл мэдээллийн арилжааны шинж олон нийтийг хамарсан, олон хувиар хэвлэгддэг гудамжны "шар" сонин цэцэглэн хөгжихөд нөлөөлж, тийм ХМХ-ийн сурвалжлагчдын мэргэжил янз бүрийн эрсдэл, хэл ам, хэрүүл шуугиан дагуулж эхэлсэн билээ. Мөн үүний зэрэгцээ мэдээллийн, арилжааны сэтгүүл зүй, ажил хэрэгч хүмүүс, элитүүдэд зориулсан ХМХ ч цөөнгүй гарах болсон юм.

Сэтгүүл зүй өөрийнхөө агуулга, хэлбэр хэв маяг, бичлэгийн төрөл зүйл, хэл найруулга, зорилго чиглэлээр өмнөх үеийнхээс эрс өөр, чөлөөтэй, олон ургальч шинжтэй болж эхэлсэн. Үзэл суртлын дарангуйлал санхүү эдийн засгийн дарангуйллаар солигдож, мөнгө, ашиг орлого бүхнийг шийдэх болсон. Сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, үнэт зүйлс үндсэндээ алдагдаж, сэтгүүлчид ашгийн төлөө юунаас ч буцахаа байсан нь нууц биш юм. Ингээд орчин үеийн

Монголын сэтгүүл зүйн онцлог шинжийг сэтгүүлчийн мэргэжлийн үүднээс дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Сэтгүүлчийн мэргэжил шинэ медиагийн орчинд өөрийн бодит дүр төрхийг хараахан олж чадаагүй, эрх хайх шатандаа явна.

- Сэтгүүл зүй ба сэтгүүлчийн мэргэжил сүлжээний болон цахим ХМХ мэдээллийн шинэ технологийн үр дүнд тодорхой хэмжээгээр даяаршлагдсан.

- Олон хэв маягтай, олон янзын дүр төрхтэй, төрөл хэлбэртэй болж чадсан бөгөөд хүлээн авагчдын хувьд сонирхолтой болж эхэлсэн.

- Бараг бүх ХМХ-д арилжааны шинж нэвт шингэсэн.

- ХМХ-ийн ихэнх хэсэг нь гудамжны "шар" хэвлэлийн шинжийг агуулах болсон.

- Ёс зүйн хэмжээ, үнэт зүйлийн чиг баримжаа үндсэндээ алдагдсан зэрэг болно.

**Д**ээр дурдсаныг нэгтгэж үзвэл мэдээллийг дамжуулагч-зуучлагчийн мэргэжил мэдээллийг урьдчилан зөн билгээр мэдэх болон дамжуулан хүргэгчээс, мэдээллийг өөрсдийн эздэд төрийн түшмэд, хэрэглэгчдэд зориулж мэдээлэл цуглуулдаг, худалддаг ажилтнуудын тусламжтайгаар хүргэдэг тусгай мэдээлэгч-сурвалжлагчаас эхлээд мэдээллийн хамгийн хүчтэй институтуудын нэг болох, мэдээллийн шинэ технологийн ачаар даяаршлагдсан, "дөрөв дэх засаглал" хэмээн нэрлэгддэг орчин үеийн сэтгүүл зүй хүртэл хувьсан хөгжиж иржээ.

Мэдээлэл дамжуулах үйл явцын хөгжлийн чиг хандлага нь урт хугацааг хамарсан нэг л утгатай, нэг л соёл иргэншлийг хамарсан зүйл биш, харин тодорхой орчилт үйл явц юм. Гэхдээ

түүхийн тодорхой хугацааны дотор мэдээлэл харилцааны үйл ажиллагаа нь шугаман хандлагын хүрээнд хувьсан өөрчлөгдсөнийг ажиглаж болно. Тэр нь:

- Урьдчилан зөн билгээр мэдэх байдлаас бодитой үйл явц руу;

- Хувь хүнээс хамт олон руу;
- Дээд түвшний хэсэг бүлгээс олон нийт рүү;

- Ганцаарчилсан ярианаас харилцан яриа руу;

- Аман хэлбэрээс бичгийн хэлбэр рүү;

- Хэвлэмэл хэлбэрээс цахим хэлбэр лүү;

- Нэг чиглэлээс (аксиаль) олон чиглэл (ретиаль) рүү;

- Мэргэжлийн бус хэлбэрээс мэргэжлийн хэлбэр руу;

- Мэдээлэх албаас утга зохиолын, уран бүтээлийн ажил руу;

- Зохион туурвих ажлаас бизнес рүү;
- Чанартай сэтгүүл зүй "шар" сэтгүүл зүй рүү шилжих үйл явц юм.

**Ү**үний зэрэгцээ өөрийнхөө оршиж байсан үе шат болгонд сэтгүүл зүйн хөгжил эсрэгээр буюу ороомог маягаар хөгжиж ирсэн нь ажиглагддаг. Өөрөөр хэлбэл "ороомог болгонд өмнөх үеийн байдалд тодорхой хэмжээгээр буцаж орох буюу мэргэжлийн сэтгүүл зүйгээс хагас мэргэжлийн сэтгүүл зүй рүү, уран бүтээлийн шинжээс мэдээллийн шинж рүү, бодит байдлаас зохиомол, бодит биш байдал руу, "шар" сэтгүүл зүйгээс чанартай сэтгүүл зүй рүү, харилцан ярианы шинжээс ганцаарчилсан яриа руу шилжиж"<sup>3</sup> байжээ. Энэ бол дэлхий дахины сэтгүүл зүйд ажиглагдах нийтлэг хандлага бөгөөд түүний зарим шинж манай орны сэтгүүл зүйн хөгжилд ч давтагдаж ирсэн юм.

Сэтгүүл зүйн мэргэжлийн хөгжил томоохон өөрчлөлтөд, тодруулж

хэлбэл радио сэтгүүл зүйд аман мэдээллийг, дүрс дуу чимээний хослолыг телевизийн сэтгүүл зүйд, дээрх бүх шинжийг цахим сэтгүүл зүйд дагнан ашиглахыг хүргэсэн юм. Орчин үеийн мэдээллийн соёл иргэншлийн зуунд зохиомол дамжуулалтын, даяаршлагдсан сүлжээний сэтгүүл зүйн эрин эхэлсэн нь бодит үзэгдэл болсон билээ. Энэхүү шинэ сэтгүүл зүйн, мэдээллийн зууны сэтгүүл зүйн зарим онцлогийг тодруулбал:

- Сэтгүүл зүй орон зай, цаг хугацааны хязгаараас үл хамааран маш эрчимтэй даяаршлагдаж байна.

- Сэтгүүл зүй даяар сүлжээнд эргэлдэж буй мэдээллийн нэгдмэл урсгалын бүхий л зүй тогтлуудад захирагдаж, мэдээллийн бусад хэв маягтай (зар сурталчилгааны, шинжлэх ухааны, ажил хэргийн, улс төрийн, уран сайхны, хувийн г. м.) харилцан хамааралтай, салшгүй холбоотой орших болсон. Үүний тод жишээ бол ХМХ зар сурталчилгааны, PR-ын чухал хэрэгсэл болж хувирсан явдал юм.

- ОНМХ дээд зэргээр шуурхай ажиллах болж, мэдээлэх, түүнийг хүлээн авах үйл явц цаг хугацаны хувьд давхцах нь энгийн үзэгдэл болсон.

- Сэтгүүл зүй олон талт үйл ажиллагаатай болж, олон нийтийн мэдээллийн, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэхээс эхлээд зугаацуулах хүртэлх янз бүрийн хэрэгцээ, сонирхлыг хангах, ямар ч үүргийг биелүүлэх чадвартай болох зэрэг шинж чанараар тодорхойлогдох болсон. Үүний зэрэгцээ сэтгүүл зүй хүлээн авагчдын янз бүрийн хэсэг, бүлгийн сонирхлоос шалтгаалан эрчимтэй төрөлжиж байна.

- Даяаршлагдсан сэтгүүл зүй хэдийгээр нийгмийн тусгай хэсэг бүлэг, түүний дотор элитийн бүлэгт мэдээлэл



хүргэж, харилцан ажиллаж байгаа ч бүхэлдээ нийтийн соёлын шинжийг агуулах хандлага давамгайлах болсон.

• Сэтгүүл зүйн мэргэжил сүлжээнд эргэлдэж буй олон нийтэд (масс) зориулсан мэдээллийн нэг хэвийн хэвшмэл бүтээгдэхүүнд захирагдаж, стандартчлагдаж, нэг загвараар ажиллах болсон. Гэхдээ сэтгүүлчийн мэргэжлийг улам бүтээлч, улам сонирхолтой, үр ашигтай болгох нөөц боломж, чадавч бий. Учир нь даяар сүлжээний харилцааны нөхцөлд бүтээлчээр ажиллах, нөөц боломжийг бүрэн дүүрэн дайчлах боломж асар их юм. Харамсалтай нь үүнийг манай сэтгүүлчид бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна.

• Сэтгүүл зүй мэдээллийг хүргэх эх бичвэр, бүдүүвч хүснэгт, өнгө, хөдөлгөөнт дүрс, дуу чимээ зэрэг янз бүрийн аргыг нэгтгэсэн нэгдмэл (синтез) шинжтэй болж байна. ОНМХ-ийн нийтлэл, нэвтрүүлэг хэл найруулга, агуулга ба хэлбэрийн хувьд олон янз, нарийн түвэгтэй болох үйл явц идэвхтэй явагдаж байна. Энэ бол шинэ сэтгүүл зүйн бас нэг гол онцог шинж юм.

• Сэтгүүл зүйд интерактив шинж буюу сэтгүүлч хүлээн авагчидтай шууд яриа өрнүүлэх, шууд ба эргэх холбоо тогтоох боломж улам бүр нэмэгдэж байна.

• Сэтгүүл зүй өөрөө өөрийгөө хянах боломж нэмэгдэж байна. Учир нь эргэх холбооны тусламжтайгаар нийтэлж, нэвтрүүлсэн материалын талаарх санал бодлыг шуурхай хүлээж авдаг болж, мэдээллийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн хүлээн авч байгаагаас шалтгаалан хянах, өөрчлөх боломж бүрдсэн.

• Мэдээлэл сэтгүүл зүйн бүтээгдэхүүний хувьд улам бүр бараа таваарын, даяар сүлжээгээр үзүүлж

байгаа бусад үйлчилгээний төрлүүдийн хамт үйлчилгээний шинжийг агуулах болсон.

• Сэтгүүлчдийн хүлээн авагчдад дамжуулах, эсвэл учир утгыг ойлгох дүн шинжилгээ хийх зорилгоор даяар сүлжээг ашиглан мэдээлэл хүлээж авах орон зай эрс өргөжиж, бодит боломж улам бүр нэмэгдэж байна. Үүнтэй холбоотой сэтгүүл зүй мэдээллийн хоёр дахь эх сурвалж болох хувирч эхэлсэн. Учир нь Интернет-сүлжээ сурвалжууд объекттай шууд танилцах нөхцөл байдлыг шууд ажиглах, үйл явдалд оролцогчидтой газар дээр нь ярилцах боломжийг хязгаарладаг.

• Сэтгүүлчийн мэргэжил ихэнх тохиолдолд “гэртээ” компьютертэй ажиллах ажил болон хувирч, өмнө үеийнх шиг заавал редакцид байнга байхыг шаардахгүй болсон. Орчин үеийн компьютерийн технологийг эзэмшихийг, гэхдээ нэлээд өндөр түвшинд эзэмшихийг шаардаж эхэлсэн.

• Мэдээллийн шинэ технологийн тусламжтайгаар олон нийтийн үзэл бодол, сэтгэл зүйгээр тоглох, хүлээн авагчдад дарамт шахалт үзүүлэх боломж нэмэгдсэн. Үүний зэрэгцээ хүлээн авагчид цахим сүлжээндээ мэдээллийг чөлөөтэй сонгох замаар мэдээллийн дарангуйллын эсрэг зогсох боломж бүрдэж байна.

• Сэтгүүлчид даяар сүлжээнд эргэлдэж буй янз бүрийн байр суурь, үзэл бодолд тэвчээртэй, хүлээцтэй хандах болсон. Мөн сэтгүүлчдэд соён гэгээрүүлэх туйлын зорилгоо биелүүлэх, хүнлэг ёсны үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хүмүүсийн оюуны хүрээг өргөжүүлэхэд нөлөөлөх асар их боломж бүрдсэн.

• Сэтгүүл зүй хүмүүсийн болон ард түмний эв нэгдлийг бэхжүүлэх, соёлын болон хувийн харилцааг эрчимжүүлэхэд

чухал нөлөө үзүүлж, энэ утгаараа соёл иргэншлийг төлөвшүүлэх чухал хүчин зүйл болж байна.

Орчин үед мэдээллийг бүтээгч, бүтээсэн зүйлийн төлөө хариуцлага хүлээх учиртай сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг урьд өмнө байгаагүйгээр өсөн нэмэгдсэн. Учир нь дэлхий ертөнц, түүний мэдээллийн талбар бохир, сөрөг мэдээллээр дүүрэх ёсгүй. Товчоор хэлбэл мэдээллийн чанар даяар экологийн тулгамдсан асуудал, соёл иргэншлийн тогтвортой хөгжлийн үндэс болж байна.

Дээрх хүчин зүйлсээс шалтгаалан сэтгүүлчийн мэргэжлийн парадокс болон логик зөрчлүүд улам тод ажиглагдах болсон. Үүнийг сэтгүүл зүй судлаачид мэргэжлийн парадоксууд (грек хэлний *paradox*, *para* – хажууд, дэргэд, *doxa* – үзэл бодол, төсөөлөл) гэж нэрлэдэг бөгөөд үгчлэн орчуулбал хоёр өөр үзэл бодлын, төсөөллийн зохицол, нэг үзэгдлийн хоёр талын хослол гэсэн утгыг илэрхийлдэг байна<sup>4</sup>. Энэхүү парадоксууд сэтгүүлчийн мэргэжлийг зөвхөн мөн чанарын хувьд төдийгүй онцлог шинжийн хувьд ч хамгийн зөрчилтэй, нарийн түвэгтэй болгодог байна. Тэгвэл сэтгүүлчийн мэргэжилд ямар парадоксууд байгааг авч үзье.

Сэтгүүлч нэг талаар үйл явдал, үзэгдлийн хамгийн гол, мөнхийн зүйлийг олж харахыг, нөгөө талаар маргааш гэхэд хэнд ч хэрэггүй, сонирхолгүй тухайн цаг үеийн мэдээллийг тусгахыг хичээдэг. Хамгийн түрүүнд энэ хоёрын хооронд парадокс оршиж

байна. Хэдийгээр сэтгүүлч ямар нэгэн үл мартагдах, мөнхийн зүйл үлдээхийг хүсдэг боловч дийлэнх олонх нь өөрийнхөө бүтээлийн хамт “үхдэг”, алга болдог. Энэ нь ялангуяа электрон мэдээллийн хэрэгслүүдийн сэтгүүлчдэд илүү их хамаатай. Өнгөрсөн зууны гуч, дөчөөд оны үед манай сэтгүүл зүйд маш олон уран бүтээлч ажиллаж байсан боловч олон түмэн тэдний ихэнхийг аль хэдийд мартсан байдаг.

«

*Орчин үед мэдээллийг бүтээгч, бүтээсэн зүйлийн төлөө хариуцлага хүлээх учиртай сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг урьд өмнө байгаагүйгээр өсөн нэмэгдсэн. Учир нь дэлхий ертөнц, түүний мэдээллийн талбар бохир, сөрөг мэдээллээр дүүрэх ёсгүй*

»

ч маргахгүй.

Сэтгүүлч бол өнөөдрийн, орчин цагийн дагуул. Түүний бүтээл нэг өдрийн настай. Гэхдээ энэхүү нэг өдрийн настай бүтээлгүйгээр хүмүүс амьдарч чадахгүй. Үүнийг 2008 оны 7-р сарын 1-ний үйл явдалтай холбоотой онц байдал зарласан хэдэн хоногийн амьдрал тод харуулсныг бид сайн мэднэ. Ямар ч мэдээлэлгүй ард түмэн хэдэн хоногийн турш шоконд орсон нь сэтгүүл зүй хэмээх нийгмийн өвөрмөц институт ямар гайхамшигтай, ер бусын нөлөөтэй зэвсэг вэ гэдгийг тов тодорхой харуулсан юм. Орчин үед хүн мэдээлэлгүйгээр амьдрах боломжгүй болсон. Тэр үйл явдлын талаар тодорхой чиг баримжаатай болж, орчин тойронд болж буй зүйлүүдтэй холбоотой өөрийнхөө зан байдлыг хянаж,



зохицуулж байх онцлогтой. Ялангуяа дайн байлдаан, хувьсгал, мөргөлдөөн, нийгэм дэх эрс шинэчлэл, дэлхий нийтийг хамарсан онц аюултай үзэгдэл зэрэг онцгой нөхцөлд ОНМХ-ийн мэдээлэл чухал үүрэг гүйцэтгэх болно.

Сэтгүүл зүйн философийн парадокс бол энэ мэргэжил нэг талаар "бүгдийг хийж чаддаг", нөгөө талаар "юу ч хийж чадахгүй" юм шиг байдаг оршдог. Сэтгүүлч бол номлогчоос шуомен хүртэлх ямар ч үүргийг гүйцэтгэж чаддаг, ямар ч аргаар юуны тухай ч бичиж чаддаг. Гэхдээ хаана ч бүрэн гүйцэд хэрэгжихгүй онцлогтой. Сэтгүүл зүй бол тухайн үед нийгэм, хэсэг бүлэг, хувь хүнд хэрэгцээтэй байгаа бүгдийг хийж болдог нэг ёсны аварга том сав юм. Хэрэв өчигдөр намын бодлогыг хэрэгжүүлэгч, сурал нэвтрүүлэгч, зохион байгуулагч байх шаардлагатай байсан тул бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ үүргийг үг дуугүй биелүүлж байв. Дараа нь өөр цаг үе ирлээ, намын хуучин үзэл суртлыг бүрмөсөн үгүйсгэх шаардлага гарсан, сэтгүүлчид үүнийг ч амжилттай гүйцэтгэж чадсан. Өнгөрсөн үед уншигч, үзэгч, сонсогчдыг зугаацуулах бус, хүмүүжүүлэх шаардлагатай байсан бол өнөөдөр хүмүүжүүлэх үүргээс татгалзаж, зугаацуулах, сенсац дэгдээх замаар олон нийтийн сэтгэл зүйгээр тоглох чиглэлийг түлхүү барьдаг болсон.

Энэ мэргэжлийн үндсэн гэж хэлж болохоор өөр нэг парадокс бол нэг талаар бие даасан байдал, үгийн эрх чөлөө, "дөрөв дэх засаглал" руу тэмүүлэх, өөрөөр хэлбэл ямар ч тэмцэлд өөрсдийн байр суурийг хадгалахыг хичээх, нөгөө талаар эзэд, төр засаг, хэвлэн нийтлэгч, үүсгэн байгуулагч, реклам олгогч, ивээн тэтгэгчдээс хараат орших явдал юм. Үүнийг бие

даасан, чөлөөт уран бүтээлч болон хувь хүн ба бүх зүйлээс, түүний дотоо олон нийтийн үзэл бодол болон хувь авагчдаас хүртэл хараат байх хоёрын хооронд оршдог маш гүнзгий зөрчил гэж хэлж болно. Мэдээллийн засаглалын асар том чадавч ба төрийн байгууллагуудаас хараат байдал хоёрын хооронд ч асар зөрчил оршдог нь энэ мэргэжлийн өөр нэг өвөрмөц шинж юм.

**И**йм хараат байдлын өөр нэг тал бол сэтгүүлч хүн бичсэн бэлтгэсэн бүтээлийн хувьд хараат оршдог явдал юм. Зохиолчийн хувь хүний хувьд бичсэн зүйл нь албаны дарга, хариуцлагатай нарийн бичгийн дарга, дугаар хариуцагч эрхлэгч зэрэг хамт олны шигшүүр бүр хяналтын үе шатыг дамжин өнгөрдөг. Энд хүн болгон өөрийн гэсэн мэдээлэл сонирхол, үзэл баримтлалтай, бас үгс төрийн үзэл бодолтой гэдэг нь тодорхой. Ихэнх тохиолдолд материалын хамгийн чухал, хэрэгтэй гэсэн хэсгийг удирдлагын хүсэл сонирхол, эсвэл сонины дугаар, хөтөлбөрийн багтаамж, эсвэл тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогоос шалтгаалан авч хаядаг нь энгийн үзэгдэл юм.

Сэтгүүлчээс байнга шаардагддаг шуурхай байдал бол энэ мэргэжлийн дотоод мөн чанарыг илэрхийлдэг онцлог шинж бөгөөд сонгож авсан асуудлыг гүнзгийрүүлэн судлах гэсэн хүсэл эрмэлзэлтэй зөрчилддөг. Ялангуяа өдөр тумын сонин, радио-, телевизийн мэдээллийн албанд ажилладаг сэтгүүлчид сэдвийг гүнзгийрүүлэн судалж, дотоод мөн чанарт нь нэвтрэх гэсэн хүсэл сонирхол байсан ч тийм боломж тэр бүр олдохгүй гэдэг нь тодорхой юм. Үүнтэй холбоотой

сэтгүүлчийн мэргэжлийн ихэнх асуудалд хөнгөн шуурхай хандах, тоймлон харуулах, өнгөц сонирхох зэрэг шинж нь үйл явдал, үзэгдлийн шалтгаан, мөн чанарыг олон талаас нь, бүрэн гүйцэд харуулах гэсэн хүсэл сонирхолтой дээд зэргээр зөрчилддөг.

Олон нийтийн янз бүрийн үзэл бодол, санал сэтгэгдлийг тусгах, бодит байдлын үнэн дүр төрхийг олон талаас нь харилцан уялдаа холбоотой харуулах шаардлага бол сэтгүүлчийн болон редакцийн субъектив шинж, нэг чиглэлийг баримтлах, үзэл сурталд баригдах, хувийн үнэлэлт дүгнэлт өгөх хандлагын эсрэг зогсдог. Өөрөөр хэлбэл энэ нь сэтгүүлчийн дур зоргоор авирлах боломжийг ямагт хязгаарлаж байдаг онцлогтой юм.

Энэ мэргэжлийн өөр нэг парадокс бол уран бүтээлч хүний хаалттай байдал, дотоод бодол, хувийн онцлог ба мэргэжлийн нийтлэг, нийгмийн шинж, нээлттэй байдлын хоорондох зөрчил мөн.

**С**этгүүлчийн асар их хэмжээний оюуны болон биеийн хөдөлмөр, эрч хүч шаардсан хүнд хэцүү ажлын дараа амрах хэсэн хүсэл нь маш ховор биелдэг. Учир нь түүний оюун тархи нь санасан бодсон нийтлэл, нэвтрүүлгийг бичих, боловсруулах, гарчиг өгөх, хүлээн авагчдын сонирхолд нийцсэн шинэ хэлбэр, бүтэц зохиомж эрж хайх зэргээр тасралтгүй ажилласаар байх болно. Сэтгүүлчид өдөр, шөнө, зав чөлөө гэж үгүй. Амарлаа гэхэд ёс төдий л амардаг. Энэ бол уран бүтээлч хүний мөнхийн зовлон, бас жаргал юм.

Сэтгүүлчийн ажил бол асар их ачаалалтай ажил гэдгийг дээр дурдсан. Энэ бол сэтгүүл зүйн үйл ажиллагааны хэв маягийн онцлогтой шууд холбоотой бөгөөд сэтгүүлчийн мэргэжлийн

парадокс хүчин зүйл гэж хэлж болно. Бүтээлч ажлыг өдөр тутмын хар бор ажилтай, утга зохиолын ажлыг зохион байгуулах ажилтай, хянан найруулах ажлыг арилжаа бизнесийн ажлын төрөлтэй хосолдог нь сэтгүүлчийг туйлд нь хүртэл ядраадаг.

Бидний дээр дурдсан парадоксууд болон бэрхшээлүүд сэтгүүлчийн мэргэжил сэтгэл зүйн хувьд хамгийн хүнд хэцүү мэргэжил гэдгийн илэрхийлэл юм. Энэхүү парадокс шинж, алхам тутамдаа учирдаг зөрчил нь сэтгүүлчийн мэргэжлийг дахин давтагдашгүй романтик шинжтэй, хурц дайчин чанартай, бусдыг өөртөө татах чадвартай, ер бусын сонирхолтой болгож, түүний нэг талаар ямар ч мэргэжилтэй төстэй биш өвөрмөц онцлогийг, нөгөө талаар бусад бүх мэргэжлийн шинжийг агуулдаг онцлогийг илэрхийлдэг. Бүтээлч ажиллагаа боловч ямагт энгийн нэг алба болон хувирдаг, чөлөөтэй, бие даасан боловч бусдаас хараат оршдог, мөнхийн боловч тухайн цаг мөчийн, сонирхолтой, өдөр тутмын, утга зохиолын, зохион байгуулалтын, байнга хөгжил хөдөлгөөнд оршдог, өдөр тутам устаж алга болдог ч мөнхийн амьд цорын ганц зүйл бол сэтгүүл зүй. Үүгээр сэтгүүл зүй гайхамшигтай, үүгээр сэтгүүл зүй дахин давтагдашгүй юм.

#### Ишлэл

- 1 2007. Новая иллюстрированная энциклопедия. М., Том VIII, с. 40.
- 2 Цит. по книге: *Свитич Л. Г.* 2003. Профессия журналист. М., с. 26.
- 3 *Черных А.* 2007. Мир современных Медиа. М., с. 26.
- 4 2003. Философский энциклопедический словарь / Ред. Е. Ф. Губский. М., с. 208.



### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2014. Нийгэм, Интернет, Сэтгүүл зүй. УБ.
2. Ворошилов В. В. 2001. Журналистика. СПб.
3. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
4. Зулькафиль М. 2014. Сэтгүүл зүйн онолын зарим асуудал. Цуврал №5. УБ.
5. Зулькафиль М. 2011. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртаас олон ургальч үзэл хүртэл. УБ.
6. Зулькафиль М. 2014. Сэтгүүлчийн мэргэжил: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
7. Ким М. Н. 2013. Основы теории журналистики. М.
8. Кин Ж. 1993. Средства массовой информации и демократия. М.
9. 2007. Новая иллюстрированная энциклопедия. М., Том VIII.
10. Свитич Л. Г. 2003. Профессия: журналист. М.

11. Тертычный А. А. 2010. Аналитическая журналистика. М.
12. 2003. Философский энциклопедический словарь /Ред. Е. Ф. Губский. М.
13. Черных А. 2007. Мир современных Медиа. М.

### Резюме

Статья посвящена актуальным вопросам развития современной монгольской журналистики и основным факторам, влияющим на содержание журналистской деятельности. Автор, анализируя практическую деятельность современных журналистов, выделяет трудности, внутренние противоречия и парадоксы данной профессии. Автор считает, эти парадоксы и внутренние противоречия делают журналистскую профессию одной из самых сложных психологически.